

[ЗҮҮНХАНГАЙ СУМ ЗДТГ]

Огноо: 2020.10.28

**[УВС АМЙГИЙН ЗҮҮНХАНГАЙ СУМЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ
ХАТУУ ЭДЛЭЛ ХУДАЛДАЖ АВАХ]
ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ**

Тендер
шалгаруулалт/
гэрээний нэр, дугаар: **СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ ХАТУУ ЭДЛЭЛ ХУДАЛДАЖ АВАХ
УВАЗХСЗДТГ/202001001**

ЗҮҮНХАНГАЙ СУМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааг бөглөх санамж

Тендерт оролцогчид Захиалагчийн шаардлагад нийцсэн тендер бэлтгэхэд шаардлагатай мэдээлэл, түүнчлэн тендер хүлээн авах, нээх, үнэлэх болон гэрээ байгуулах эрх олгох үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг энэ бүлэгт тусгана. Захиалагч тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа тендерт оролцогчдод өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.

Гүйцэтгэгчийн гэрээний үүрэг, гэрээний төлбөр, талуудын эрх, үүрэг, хүлээх эрсдэлтэй холбогдсон нөхцөлийг энэ бүлэгт бус 4 дүгээр бүлэгт буюу гэрээний ерөнхий нөхцөл болон 5 дугаар бүлэгт буюу гэрээний тусгай нөхцөлд тус тус заана.

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа нь гэрээний хэсэг болохгүй.

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- | | |
|--------------------------------------|--|
| 1. Тендерийн цар хүрээ | <p>1.1. Энэ тендерийн баримт бичгийн 2 дугаар бүлэг буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (ТШӨХ)-д тодорхойлсон захиалагч (цаашид “захиалагч” гэх) нь ТШӨХ, техникийн тодорхойлолт болон VI бүлэг буюу гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д дурдсан ажил (цаашид “ажил” гэх)-ыг гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна. Ирүүлсэн тендерүүдээс хамгийн сайн тендерийг ТББ-ийн дагуу үнэлж, шалгаруулах ба уг тендерийг ирүүлсэн оролцогч (цаашид “шалгарсан тендерт оролцогч” гэх)-той ГТН болон ТШӨХ-д дурдсан нэр, дугаар бүхий гэрээг байгуулах болно.</p> <p>1.2. Шалгарсан тендерт оролцогч нь гэрээгээр гүйцэтгэх ажлыг ТШӨХ болон ГТН-д заасан ажил дуусгах хугацаанд багтаан дуусгана.</p> <p>1.3. Ажил нь ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд нэг багцтай байна.</p> |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр | <p>2.1. Захиалагч дээр дурдсан барааг ТШӨХ-д тодорхойлсон эх үүсвэрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.</p> |
| 3. Эрх бүхий тендерт оролцогч | <p>3.1. Тендерийн урилга нь эрх бүхий тендерт оролцогч бүрт нээлттэй. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 9.3 дахь хэсэгт заасныг үндэслэн гадаадын этгээдийг тендерт оролцуулахгүй байхаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд тендерт оролцогч болон тендерт оролцогч түншлэлийн гишүүн бүр нь аль ч улсын харъяалалтай байж болно.</p> <p>3.2. Дараах тохиолдолд тендерт оролцогч (түншлэлийн гишүүн бүрт нэгэн адил хамаарна)-ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:</p> <p>4.2.1 Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;</p> <p>4.2.2 Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;</p> <p>4.2.3 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг;</p> <p>4.2.4 Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;</p> <p>4.2.5 Тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн</p> |

этгээдтэй нэгдмэл сонирхолтой;

- 4.2.6 Илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон;
- 4.2.7 Сүүлийн 3 жилийн хугацаанд Авилгын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авилгын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;
- 4.2.8 Тендерт оролцогч нь (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) уг төслийн зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээг хянах зөвлөхөд нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой бол;
- 4.2.9 Энэхүү тендер шалгаруулалтад хоёр буюу түүнээс дээш тооны тендерт оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;
- 4.2.10 Энэхүү тендерийн баримт бичгийн 16 дүгээр зүйлд хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тухайн тендер шалгаруулалтад аливаа тендерт оролцогч нэгээс дээш тендер ирүүлсэн бол; (Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй)
- 4.2.11 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь захиалагчаас хараат буюу улсын төсвөөс санхүүждэг, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаггүй, Компаний тухай хуулиар үйл ажиллагаа нь зохицуулагддаггүй, бүтэц зохион байгуулалтын хувьд захиалагч байгууллагад шууд харьяалагддаг бол.
- 3.3. Тендерт оролцогч 4.2.1 - 4.2.11-д дурдсан нөхцөл үүссэн эсэх мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.
- 3.4. Тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно. Үүнд:
- (а) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар, эсвэл үүсгэн байгуулагдсан улсын түүнтэй адилтгах бусад баримт бичиг;
- (б) тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл;
- (в) ТШӨХ-д шаардсан бол тухайн төрлийн бараа нийлүүлэх тусгай зөвшөөрөл;
- (г) Шүүх, эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэр. Тендерт оролцогчийн хувьд ТООЗ-ны 4.2.2, 4.2.4, 4.2.6 болон 4.2.7 – д дурдсан нөхцөл байдал үүсч байсан бол энэ тухайг

захиалагчид мэдэгдэж холбогдох шүүх, эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийг тендерийн хамт ирүүлэх үүрэгтэй.

4. Тендерт оролцогчийн гэрээг хэрэгжүүлэх чадвар

- 4.1. Бүх тендерт оролцогч нь IV бүлэгт заасан “Тендерийн маягт, Чадварын мэдээлэл, Зөвшөөрлийн бичиг/Letter of Acceptance болон Гэрээний маягт” –ын дагуу мэдээлэл ирүүлэх, ажил гүйцэтгэхээр санал болгож буй аргачлал болон хуваарь, шаардлагатай бол зураг, ажлын графикийн хамт ирүүлэх ёстой.
- 4.2. Хэрэв захиалагч урьдчилсан сонголт явуулаагүй бөгөөд ТШӨХ-д өөрөөр заагаагүй бол бүх тендерт оролцогч нар гэрээг хэрэгжүүлэх чадварыг тогтооходой холбогдуулан захиалагчийн шаардсан дараах мэдээллийг нотлох баримт болгон тендерийн хамт ирүүлнэ. Үүнд:
- (а) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн дагуу хийгдэх ажлын тухайд уг ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн эхээс хийсэн хуулбар, тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл;
 - (б) санхүүгийн чадавхийг харуулах сүүлийн ТШӨХ-д заасан тоо бүхий жилийн санхүүгийн тайлан. Хэрэв ТШӨХ-д тусгайлан заасан бол санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байна;
 - (в) гэрээг гүйцэтгэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;
 - (г) ТШӨХ-д заасан жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн барилгын ажлын нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт;
 - (д) тухайн тендерт оролцогч ТШӨХ-д заасан жилийн хугацаанд төрөл болон хэмжээгээр ижил төстэй ажил хийж гүйцэтгэсэн туршлагыг жил жилээр харуулсан мэдээлэл, одоо хийж байгаа болон хийхээр төлөвлөсөн ажлын тухай дэлгэрэнгүй мэдээлэл, тэдгээр гэрээний талаар лавлах мэдээлэл авч болох үйлчлүүлэгч, захиалагчийн хаяг;
 - (д) гэрээг гүйцэтгэхэд ашиглагдах санал болгож буй үндсэн машин механизм, тоног төхөөрөмжийн нэр төрөл;
 - (е) гэрээг гүйцэтгэхэд эргэлтийн хөрөнгө хүрэлцээтэй эсэхийг нотолсон баримт бичиг (үүнд зээл авах баталгаажсан боломж болон боломжтой санхүүгийн бусад эх үүсвэр);
 - (ё) захиалагч тендерт оролцогчийн харилцагч банкнаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл;
 - (ж) одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл;
 - (з) ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийн дүнгийн 10-аас дээш хувьтай тэнцэх ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх бол түүнийг түншлэл гэж үзэж, түншлэгч компанийн талаарх мэдээллийг мөн ирүүлнэ. Туслан гүйцэтгүүлэх ажлын талаарх мэдээллийг тендерийн саналд тусгаж ирүүлнэ. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох ажлын нийт өртөгийн дээд хязгаарыг ТШӨХ-д

тодорхойлно.

- 4.3. Тендерт оролцогч ТООЗ-ны 1.1-д заасан ажил гүйцэтгэх тухай гэрээг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангасан байна: Үүнд:
- (а) ТШӨХ-д заасан жилийн хугацаанд гүйцэтгэсэн барилгын ажлын нийт мөнгөн дүнгийн нэг жилд гүйцэтгэсэн ажлын арифметик дундаж борлуулалтын хэмжээ нь ТШӨХ-д заасан мөнгөн дүнгээс багагүй байх;
 - (б) сүүлийн ТШӨХ-д заасан жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй, доод тал нь нэг удаагийн ажил гүйцэтгэх гэрээний үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлага(энэ шаардлагыг хангахын тулд нэрлэсэн ажлын доод тал нь 70 хувь нь гүйцэтгэгдсэн байх шаардлагатай);
 - (в) ТШӨХ-д заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цаг хугацаанд нь олж (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах санал;
 - (г) гэрээнд заасан ажилтай төрөл, дүнгээрээ дүйцэх ажил дээр ТШӨХ-д зааснаас доошгүй жил, түүний дотор ТШӨХ-д зааснаас доошгүй жилд нь гэрээг хариуцаж ажилласан туршлага бүхий ерөнхий инженертэй байх;
 - (д) бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл нь ТШӨХ-д дурдсан дүнгээс багагүй байх.
- 4.4. Тендерт оролцогч түншлэлийн хувьд 5.3 (а) ба (д)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ. Гэхдээ гишүүн тус бүр 5.3 (а), (б) болон (д) -д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байх ёстой. Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд түншлэлийг тухайн чадварын шаардлагыг хангаагүй гэж үзэж тендерээс нь татгалзана. Тендерт оролцогч 5.3(б), (в), (г)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн нөөц бололцоог хамтад нь харгалзан үзнэ.
- 4.5. Тендерт оролцогч чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлоход түүний туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, санхүүгийн нөөц бололцоог харгалзан үзэхгүй. Гэвч туслан гүйцэтгэгчийн гүйцэтгүүлэх ажилд тусгай зөвшөөрөл шаардагдах бол туслан гүйцэтгэгч уг шаардлагыг хангасан байвал зохино.
- 4.6. Тендерт оролцогч тендерийн үнэлгээнд 7.5 хувийн давуу эрх эдлэх хүсэлтэй бол тендерт оролцогч нь Монгол Улсын хуулийн этгээд бөгөөд түүний өмчийнх нь 50-иас дээш хувийг Монгол улсын иргэн, хуулийн этгээд эзэмшдэг, түүнчлэн ажил гүйцэтгэх гэрээний 50-иас дээш хувийг уг этгээд гүйцэтгэнэ гэдгийг нотлон ирүүлэх шаардлагатай.

Г. ТЕНДЕР ИРҮҮЛЭХ

- | | |
|---|---|
| 5. Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх | <p>5.1. Тендерт оролцогчид өөрийн тендерийг бичгээр үйлдэж шуудангаар, эсвэл өөрөө буюу өөрийн бие төлөөлөгчөөр цахимаар захиалагчид хүргүүлнэ.</p> <p>5.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг тус тусад нь “ЭХ ХУВЬ”, “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж битүүмжлэн тэдгээрийг дахин давхар нэг дугтуйнд (гаднах) хийж битүүмжлэнэ. Тендерээ дугтуйлж, битүүмжлэхдээ ТООЗ-ны 23.3, 23.4 –т заасныг баримтлана.</p> <p>5.3. Доторхи ба гаднах дугтуйнууд дараах шаардлагыг хангасан байх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> (а) тендерт оролцогчийн нэр, хаягтай байх; (б) ТШӨХ-д заасан хаягаар ТООЗ-ны 1.1-т заасан захиалагчийн нэр дээр хаяглах; (в) Тендер шалгаруулалтыг таних, ялгах тэмдэг болгож ТООЗ-ны 1.1 болон ТШӨХ-д тодорхойлсон тендер шалгаруулалтын нэр/дугаар тодорхой бичигдсэн байх; (г) ТООЗ-ны 27.1-т заасан хугацаанаас өмнө “НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэж тэмдэглэгдсэн байх. <p>5.4. Хэрэв бүх дугтуйг 23.3-т заасан шаардлагын дагуу битүүмжилж, бичиглэл хийгээгүй нөхцөлд уг тендер буруу хаягаар хүргэгдсэн, эсхүл тендер нээхээс өмнө битүүмжлэл задарсанд захиалагч хариуцлага хүлээхгүй.</p> <p>5.5. ТООЗ-ны 23.1-т зааснаас өөр хэлбэрээр (электрон шуудангаар, эсвэл факсаар г.м) ирүүлсэн аливаа тендерийг захиалагч “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 27.2-т заасныг үндэслэн хүлээж авахгүй бөгөөд түүнийг хаягаар нь буцаана.</p> |
| 6. Тендер хүлээн авах эцсийн хугацаа | <p>6.1. Захиалагч тендерүүдийг ТООЗ-ны 23.3-т дурдсан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>6.2. Захиалагч ТООЗ-ны 12 дугаар зүйлийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон тендерт оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.</p> |
| 7. Хугацаа хоцорсон тендер | <p>7.1. Захиалагч 24 дүгээр зүйлд заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа тендерийг “хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.</p> |
| 8. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах | <p>8.1. Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчид бичгээр мэдэгдэл өгсний үндсэн дээр өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцааж авах эрхтэй.</p> <p>8.2. Тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл тендерийг буцааж авах мэдэгдлийг ТООЗ-ны 23 дугаар зүйлийн дагуу бэлтгэн битүүмжилж, бичиглэл хийхийн хамт доторхи ба гаднах дугтуй дээр “НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ ТУХАЙ”, “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ”, эсхүл “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн нэмэлт бичиглэл хийж ТООЗ-ны 24 дүгээр зүйлд заасны дагуу захиалагчид ирүүлнэ. Тендерийг буцааж авах мэдэгдлийг утсан холбоогоор ирүүлж болох ба энэ мэдэгдэл хүчин төгөлдөр болохыг батламжилж гарын үсэг, тамга бүхий эх хувийг тендер хүлээн авах</p> |

эцсийн хугацаанаас өмнө заавал ирүүлнэ.

- 8.3. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш тендерт аливаа нэмэлт өөрчлөлт хийхийг хориглоно.
- 8.4. ТООЗ-ны 26.2-т заасны дагуу тендерээ буцааж авах тухай хүсэлт ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүй буцаан олгоно.
- 8.5. Тендер хүлээн авах эцсийн хугацаа өнгөрсөнөөс хойш ба тендер хүчинтэй байх хугацаа өнгөрөөгүй тохиолдолд аливаа этгээд тендерээ буцааж авах нь ТООЗ-ны 21.8.(а)-д заасны дагуу түүний тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болно.

Е. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ

9. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур

- 9.1. Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд 34.6-д заасны дагуу хамгийн сайн гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.
- 9.2. Хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТООЗ-ны 31 дугаар зүйлийн дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй эсвэл бичгээр хариу ирүүлээгүй бол захиалагч түүний тендерээс татгалзах бөгөөд 21.8.(б)-д заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгож, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 29.3 дахь хэсэгт заасныг үндэслэн удаахь хамгийн сайн үнэлэгдсэн тендер шрүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

10. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

- 10.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдэгдлийг тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө шалгарсан тендерт оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.
- 10.2. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг мэдэгдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор гэрээг баталгаажуулж гарын үсэг зурахыг хориглоно. Энэ заалтыг зөрчиж байгуулсан гэрээ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 42.1.2-т зааснаар хүчин төгөлдөр бус гэрээ гэж тооцох үндэслэл болно.
- 10.3. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл нь гэрээ байгуулах үндэслэл болно. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл гаргаснаар тендерт оролцогч 38 дугаар зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлж, 37 дугаар зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурах хүртэл захиалагч гэрээ байгуулах эрх авсан тендерт оролцогч нарын хооронд хэлцэл хийгдсэн гэж үзнэ.
- 10.4. Захиалагч нь Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас www.e-procurement.mn вэб сайтад тендерийн нэр болон багцийн дугаарыг дараахь мэдээллийн хамтаар нийтэлнэ:
 - 1) Тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;
 - 2) Тендерийн нээлтэнд зарлагдсан үнийн саналууд;
 - 3) Нарийвчлан үнэлэгдсэн тендерийн нэр, үнийн санал;
 - 4) Тендерээс нь татгалзсан оролцогчийн нэр, татгалзсан шалтгаан;
 - 5) Тендерт шалгарагчийн нэр, түүний санал болгосон үнэ,

түүнчлэн батлагдсан гэрээний дүн.

10.5. Гэрээ байгуулсан тухай мэдээлсний дараагаар, шалгараагүй тендерт оролцогч тендерийг нь татгалзсан үндэслэл, шалтгааны талаар тайлбар ирүүлэх хүсэлтийг бичгээр гаргаж болно. Ийм хүсэлт гаргасан тохиолдолд захиалагч бичгээр хариу өгнө.

10.6. Шалгарсан тендерт оролцогч ТООЗ-ын 38 дугаар зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлж, гэрээнд гарын үсэг зурсны дараагаар захиалагч ТООЗ-ын 21.6-д заасан хугацаанд тендерийн баталгааг цуцлах талаар бусад тендерт оролцогч нарт мэдэгдэнэ.

11. Гэрээнд гарын үсэг зурах

11.1. Захиалагч нь гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлүүдийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.

11.2. Шалгарсан тендерт оролцогч нь гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хоногийн дотор түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТШӨХ)

Тухайн тендер шалгаруулалтын үр дүнд гүйцэтгэх ажлын талаарх дор дурдсан өгөгдөл нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТООЗ/-ны холбогдох зүйл, заалтад нэмэлт мэдээлэл оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТООЗ-ны зүйл заалттай зөрчилдвөл энэхүү ТШӨХ-д дурдсан мэдээллийг зөв гэж үзнэ.

ТООЗ-ны холбогдох заалт	А. Ерөнхий зүйл
ТООЗ 1.1	Захиалагч нь: [Зүүнхангай сум ЗДТГазарт]
ТООЗ 1.1	Ажлын буюу гэрээний товч нэр, тодорхойлолт : [бараа]
ТООЗ 1.1	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар нь: [СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ ХАТУУ ЭДЛЭЛ ХУДАЛДАЖ АВАХ]
ТООЗ 1.2	Ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь: [2020.11.28]
ТООЗ 1.3	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: [багцгүй]
ТООЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: [Орон нутгийн хөгжлийн сан ¹]
ТООЗ 4.4.(в)	Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: [“гүй” .]
ТООЗ 18.1	Тендерийн валют: [төгрөг .]
ТООЗ 20.1	Тендер хүчинтэй байх хугацаа нь тендерийг нээснээс хойш [14 хоног] хоногийн туршид хүчинтэй байна.

¹ Жишээ нь: Улсын төсвийн хөрөнгө, орон нутгийн төсвийн хөрөнгө, тухайн байгууллагын өөрийн хөрөнгө, эсвэл зээлийн хөрөнгийн эх үүсвэр г.м –ийг тодорхой бичнэ.

ТӨӨЗ 21.1	<i>[Дараах сонголтуудаас аль тохирохыг үлдээ]</i> (а) Тендерийн баталгаа шаардлагагүй;
	Г. Тендер ирүүлэх
ТӨӨЗ 23.3 (б)	Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Тендер хүлээн авах этгээд: <i>[Зүүнхангай ЗДТГазар санхүү алба 1 давхар 105 тоот]</i>
ТӨӨЗ 23.3 (в)	Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: Цахимаар
ТӨӨЗ 24.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <i>[2020 оны 11 дүгээр сарын 13 -ны өдөр]</i> Цаг: <i>[15 цаг 30 минут]</i>
	Д. Тендерийг нээх, үнэлэх
ТӨӨЗ 27.1	Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Аймаг, хот: <i>[Увс аймаг зүүнхангай сум]</i> Шуудангийн дугаар: <i>[92065001, 93019015 ,97190323]</i> Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: <i>[2020 оны 11 дүгээр сарын 13 -ны өдөр]</i> Цаг: <i>[16 цаг 00 минут]</i>
ТӨӨЗ 33.1	Дотоодын давуу эрх тооцохгүй

№ ТШМ-1

ТЕНДЕРИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн бичиг баримтын дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн бичиг баримтад заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

Тендерт оролцогчийн нэр: _____

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга: _____

Албан тушаал, нэр: _____

Хаяг: _____

МАЯГТ № ТШМ-4

ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ
(Захиалагчийн албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр бичнэ)

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлийг бичих санамж

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 32 дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл нь хэлцэл хийгдсэн гэж үзэх үндэслэл болно. Захиалагч энэхүү гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг зөвхөн шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.

[огноо]

[Гүйцэтгэгчийн нэр]-ийн дарга _____ Танаа,

Гэрээ байгуулах эрх олгох тухай

[Гэрээний тусгай нөхцөлд заасан тендер шалгаруулалт/ гэрээний нэр ба дугаар]-ыг [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] гүйцэтгэхээр [огноо]-нд ирүүлсэн танай тендерийг тендерт оролцогчдод өгөх зааварчилгаанд тусгасны дагуу залруулга, тохируулга² хийсэн байдлаар манай байгууллага хүлээн зөвшөөрснийг мэдэгдье.

Энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш **[моо]³** хоногийн дотор гэрээний маягтад гарын үсэг зурж ирүүлнэ үү.

Шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгааг энэхүү мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор ирүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох үндэслэл болно.

Гэрээний маягт, нөхцөлүүдийг хавсаргав.

Захиалагч байгууллагын нэр: _____

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга: _____

Албан тушаал, нэр: _____

Хаяг: _____

² Шаардлагагүй бол “залруулга”, эсхүл “тохируулга” гэснийг арилгана. Дараагийн хуудасны “Гэрээний жишиг маягтын санамж”-ийг үз.

³ Тендерт оролцогчид өгөх зааварчилгааны 33.2-т бичсэн тоотой ижил байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

БАТЛАВ: СУМЫН ЗАСАГ ДАРГА

Handwritten signature
Ж.БАТБАЯР

СУМЫН 2020 ОНХС-ЫН ХӨРӨНГӨӨР СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ ХАТУУ
ЭДЛЭЛ ШИНЭЧЛЭХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ


№		
1	Захиалагчийн нэр	Увс аймгийн Зүүнхангай сумын ЗДТГ
2	Бараа, ажил, үйлчилгээний нэр	ЕБС-н дотуур байрны хатуу эдлэл шинэчлэх
3	Тендер шалгаруулалтын дугаар	УВАЗХСЗДТГ/202001009
	Техникийн тодорхойлолт	
	А. Зориулалт	Тавилга
	Б. Хэрэглээ	Сурагчид амьдрах орчиндоо ашиглах
	В. Чанарын түвшин	Эдэлгээ даахуйц цэвэр модон байх
4	Д. Техникийн үзүүлэлт	<ol style="list-style-type: none"> 1. Цэвэр модоор хийгдсэн байх 2. Шкабууд 4 ба 2 хаалгатай байх 3. Шкабнууд дотроо олон нүдтэй байна. 3. Шкабны нугас бат бөх сугардаггүй нугас байх 4. Ширээ нь мөн модоор хийгдсэн бат бөх байх 5. Сандлууд гэрийн хэрэглээнд зориулагдсан түшлэггүй жижиг сандлууд байна. 6. Сандал ширээний харьцаа тохирсон хүүхдийн нуруунд тохирсон байх
	Е. Тоо хэмжээ	<ol style="list-style-type: none"> 1. шкаб-10 ш <p>Үүнээс: 4 хаалгатай шкаб 6 ш 2 хаалгатай шкаб 4ш</p> <ol style="list-style-type: none"> 2. ширээ-10 3. сандал-60ш 4. коридорын төмөр түшлэгтэй сандал-1ш

Техникийн тодорхойлолт боловсруулсан:

.....*Handwritten signature*..... М.Наранцэнгэл /Сургуулийн захирал /

..... М.Бямбадорж /Санхүү албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/

.....*Handwritten signature*..... Б.Даваасамбуу /Сургуулийн нярав/



ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Гэрээний ерөнхий нөхцөлийн санамж

Гэрээний ерөнхий нөхцөл болон гэрээний тусгай нөхцөл, түүнд заасан бусад бичиг баримт нь хоёр талын эрх үүргийг тодорхойлох бичиг баримт болно.

Энэ гэрээний ерөнхий нөхцөлийг нийт үнийн гэрээнд шууд хэрэглэж болно. Нэгж үнийн гэрээнд хуудасны зүүлтийг баримтлан өөрчлөлт хийн хэрэглэж болно.

Гэрээний ерөнхий нөхцөлд өөрчлөлт оруулах шаардлагатай бол үүнийг гэрээний тусгай нөхцөлд тусгаж өгнө.

МАЯГТ № ГМ-1

БАТЛАВ.

ЗӨВШӨӨРСӨН⁴.

ЗАХИАЛАГЧ	ГҮЙЦЭТГЭГЧ	[Санхүүжилтийн эрхийг нээх байгууллага, удирдах албан тушаалтан]
_____	_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр]** (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний, барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “ажил” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс :
Төвлөрсөн төсвөөс: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг;
Орон нутгийн төсвөөс: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг;
Өөрийн хөрөнгө: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг.
- Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.
- Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний бичиг баримт” гэх). Үүнд:

5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

⁴ Хэрэв санхүүжилтийн эрхийг нээх байгууллага, захиалагч хоёр нэг этгээд бол энэ хэсгийг хасна.

- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг⁵;
- 5.3. Тендер;
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь⁶;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

⁵ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

⁶ Нэгж үнийн гэрээнд “үе шатны ажлын хуваарь” гэснийг “ажлын тоо хэмжээ” гэж солино.

